

ХАРХОРУМЫН “ХААНЫ ОРДНЫ ДҮҮРЭГ” ХЭМЭЭГЧИД ХИЙСЭН МАЛТЛАГА

Нүүдэлчдэд өөрийн гэсэн нутаг ус, харьяалал гэж байдаггүй мэтээр түүх хийгээд ард түмнүүдийн тухай сонгодог тодорхойлолтод хаширсан өрөөсгөл дүр зургийг залруулахыг хүссэн хэн боловч тэд хот сууринг хэрхэн байгуулж, тэдний зүгээс хотууд болон хөгжлийн төвүүдтэй ямаршуухан харьцаатай байсныг судлах хэрэгтэй юм. Төв Азийн нүүдэлчид төр улсаа болон хот суурин байгуулж явсан түүх лавтайяа Сүннүгийн үе буюу МЭӨ III зуунаас өөр хоорондоо нягт үйлдээтэй явж ирсэн байдаг. Нүүдэлчдийн төр улсын түргэн зуур өөрчлөгдөж, орчиндоо дасан зохицох чадварыг юуны өмнө дундад зууны үеийн нүүдэлчдийн “холимог соёл”-ыг агуулсан хот байгуулалт илтгэн харуулдаг бөгөөд хот суурингийн малтлагаас олдсон эд зүйлс, тэрчлэн хотын барилга байгууламжууд, хот төлөвлөлт, байшин барилгын ур хийц, техник тоног төхөөрөмж зэргээс тэдний зохион байгуулах гарамгай чадавхи харагддаг билээ.

Нүүдэлч морьтнууд өөрсдийн ноёрхлыг тогтоон тулгар төрөө байгуулах явцад нүүдэлчдийн төвлөрсөн суурин газрууд ямар үүрэг гүйцэтгэж асан, тэд хотыг хэрхэн үүсгэн байгуулж, хөгжүүлж ирснийг илтгэх хосгүй жишээ нь эртний Монголын нийслэл Хархорум аргагүй мөн. Монголын өр зүрх болсон Орхоны хөндийд байрлах Хархорум бол монголчуудын бусдаас ялгарах өвөрмөц онцлогийг илтгэн харуулж чадахуйц газар юм. XIV зууны үеийн түүхийн нэн чухал гэрч баримтуудын нэг болох 1346 оны Хархорумын бичээст тэмдэглэсэнээр Хархорум нь Монголын тулгар төрийн үндсийг тавьсан чухамхүү тэр газар мөн аж.

Монголын түүхэн дэх Монголын Их Эзэнт гүрний гялалзсан оргил үе, мандал бадрал, мөхөл доройтол, түүнчлэн монголчууд өөр хоорондоо хэрхэн эвлэлдэн нэгдэж, сарнин бутарч явсныг

Хархорумын эрээнтэй бараантай түүх бүрнээ харуулдаг агаад энэ талаар түүнтэй эн зэрэгцэх өөр газар бараг үгүй буй заа. Энэхүү нийтлэлдээ би Хархорумыг судлах Монгол-Германы хамтарсан шинжилгээний ангийн хийсэн археологийн шинэхэн судалгаанууд, тэдгээрийн урьдчилсан дүн, ялангуяа Хархорумын “Хааны ордны дүүрэг” хэмээн нэрийдсэн тэр хэсэгт Германы Судалгааны Нийгэмлэг (ГСН)-ийн дэмжлэгтэйгээр Германы Археологийн Хүрээлэнгээс хийсэн малтлага ямар үр дүнд хүрсэн талаар товч боловч танилцуулахыг зорилоо.

Дундад зууны үеийн Хархорум хотын туурь нь (дорнод уртрагийн 102° 50', умард өргөргийн 47° 12') Хангай нурууны бэл хормойд далайн түвшнээс дээш 1500 орчим метрийн өндөрт, Эрдэнэ зуу хийдээс хойшоо 1.5 километр газарт сунаж байрласан байна. Хэрмээр хүрээлэгдсэн хотын талбай нэг их томгүй, ердөө л 1,3 хавтгай дөрвөлжин километр орчим. Бусад хотуудтай харьцуулж үзвэл, Альпийн нуруунаас умард зүгт орших XIII зууны үеийн нэлээд чухал төвүүд байсан Брюгге, Көйльн хотууд нь тухайн үедээ 3-6 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрийг эзэлж байсан бол VIII-IX зууны үеийн Уйгур улсын нийслэл Хар Балгас (qar-a balyasun)-ыг бүр 25 хавтгай дөрвөлжин километр талбайд тархан байрлаж байсан гэж үздэг. Хархорум нь нийтдээ дөрвөн хаалгатай, талбай нь бараг л тэгш өнцөгт хэлбэртэй, шавраар зуурч хийсэн ханан хэрмээр хүрээлэгдсэн барилга байгууламж бүхий хот байсан. Умраас өмнө, өрнөөс дорно зүгийг чиглэсэн гол гудамжуудын уупзвар нь хотыг дөрвөн дүүрэгт хуваасан голч тэнхлэг болж өгдөг байв. Тухайн үеийн түүхийн хамгийн чухал гэрчүүдийн нэг, Фламандарын Францискийн урсгалын гэлэн Вильхельм фон Рубрук 1256 онд зохиосон түүхийн тэмдэглэлдээ Хархорум хотын суурин байшин барилга бүхий хоёр дүүргийн талаар тодорхойлон бичсэн байдаг. Тэдгээрийн нэгний тухайд “хотын худалдаа наймааны долоо хоног тутмын зах байрлах сарацинуудын хороололд олон худалдаачид хуран цугларна”, мөн энд “олон нийтийн хурал цуглааны талбай” байрладаг гэсэн бол нөгөөгийнх нь талаар “катай (умард нутгийн хятадууд) нарын хороолол нь тэр аяараа гар урчууд” гэжээ. Хархорумын баруун урд хэсэгт байрлах “Хааны ордны дүүрэг” (240 x 250 метр) хэмээгч нь хотын доторх тусгай хот юм.

Хархорум хотыг Чингис хаан 1220 онд анх үндэслэсэн боловч Зүрчидийн Алтан Улсыг мөхөөж, Умард Хятадыг бүрмөсөн эзэлж авсны хойно (1234) л түүний гутгаар хөвгүүн, хаан ширээг нь залгамжлагч өгөдэй хаан 1235 онд ханан хэрмээр хүрээлсэн байнгын суурин хот болгож эмхлэн байгуулав. 1260 оныг хүртэл Хархорум хот нь Монголын Их Эзэнт улсын нийслэл хот байлаа. Их гүрний нийслэлийн хувьд Хархорум нь тус улсад харьяалагдах зүсэн зүйлийн ард зон хуран цугларч, олон янзын соёл уулзалдан нийлэх космополитикийн төв цэг, XIII-XIV зууны үеийн соёлын болон цаг үеийн олон урсгалыг дотроо агуулсан томоохон хайлшны тогоо болон хувирсан байв.

Дундад зууны үеийн морьтон нүүдэлчдийн ертөнцөд энэхүү хотын ач холбогдол нь зөвхөн арын алба залгуулах, үлдэж хоцорсон эхнэр хүүхэд, өндөр настнууд болон гарын ур дүйтэй цэргийн олзлогдогсдын хоргодох суурин газар, худалдаа наймааны зах, бараа таваарын болон шинэ санаа онооны өргөлтийн цэг төдийхнөөр хязгаарлагдаж байгаагүй юм. Уйгур, кидан, монголчуудын хувьд Хархорум хот нь Эзэнт гүрний засаг захиргааны уураг тархи, соёлын төв, хамгийн дээд шатны шүүх бөгөөд эртний түрэг хэлний нэгэн бичээст гардагчлан “умард, өмнөд, өрнө, дорно зүгт амьдран суух бүхий л ард олон хүрэлцэн ирдэг” Эзэнт гүрний халдашгүй дархан, өөрийн гэсэн дүр төрхийг илэрхийлэгч төв нь болон хувирсан байлаа.

Нүүдэлчдийн зарим нэг эзэнт улсын хувьд хот суурин гэдгийг зөвхөн дээрэм тонуулаар олсон зүйлээ цуглуулан хадгалах газар, алба, гувчуураар хүчээр хуримтлуулсан эд хөрөнгөө хурааж байдаг агуулах савтай адилтган ойлгож, хот байгуулалт нь тэдний тухайд булаан эзлэх дээрмийн бодлогын нэгэн хэрэгсэл байсан байж болох талтай ч хот суурингууд анх байгуулагдсан цагаасаа л эрх мэдэл, засаг захиргааны төв болж байснаараа дээрхээс хавьгүй өргөн агуулгатай байсан юм. 1235 онд Хархорум хотыг босгосон нь дайнч морьтнуудын хэврэгхэн ноёрхлын хэлбэрээс суурин ба нүүдэлчин иргэд эн тэгш зэрэгцэн оршдог эмх цэгцтэй, тогтвортой төрийн хэлбэрт, цог жавхаатай нэгэн удирдагчийн хэврэгхэн ноёрхлоос тогтвортой, мэргэшсэн зохион байгуулалт бүхий төрт улсын хэлбэрт шилжих чиглэлд шийдвэрлэх алхам болсон бөгөөд

энэхүү улсын амьдрах болон амьдралыг даван туулах чадвар нь дан ганц дээрэм тонуулаар амьдардаг нүүдэлчин угсаатны дайнд хэр аз хийморьтой байх дээр тогтдогоо болилоо.

Чингис хаан монгол үндэстнийг бий болгогчийнхоо хувьд монгол төр үүсэн байгуулагдах үндэс суурийг үндсэнд нь мөн тавьсан хүн юм. Харин монгол төрийг гардан байгуулсан хүн нь Өгэдэй хаан бөгөөд түүний төр улс тухайн үедээ бүрэн боловсронгуй болж хараахан чадаагүй ч дараа нь Мөнх, Хубилай хаадын үед оргил цэгтээ хүрч төгс хэлбэрээ олсон билээ. Өгэдэй болон Мөнх хаан, тэднээс илүүтэйгээр Хубилай хааны үед Хархорум хот өөрөө төрийн тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг, хот байгуулалт нь Монголын Эзэнт гүрний төрийн үзэл суртлыг тээгч, их гүрний үзлийнх нь бодит илэрхийлэл болжээ.

“Хавар цагт (1235 оны) Эзэн хаан Хо-линийг бэхэлж, Ван-ань ордныг (“Түмэн амгалангийн” буюу “Мөнхийн энх амгалангийн” ордон) бариулав.”

Эзэн хааны ордон, мөн түүнтэй нэгэн зэрэг баригдсан зарим сүм дуган, тэдгээрийн дотор 1346 оноос “Юань улсын эхэн үеийн асар” хэмээн нэрлэгдэх болсон Бүддийн шашны асар сүм-суваргыг “Юань Улсын түүх” (Yuanshi) болон 1346 оны Хархорумын бичээст тус хотын хамгийн анхны барилга байгууламжууд хэмээн тэмдэглэн үлдээжээ. Эдгээрийг 1235 онд, хотыг хүрээлсэн ханан хэрэмтэй хамт нэгэн зэрэг барьж байгуулсан, харин хааны ордныг жил хүрэхгүй хугацааны дотор барьж дуусгасан байна.

“Хаврын (1236 оны) тэргүүн сард хан хөвгүүд бүгдээр Ван-ань ордныг барьж дуусгасны баярт хуран чуулахаар бэлтгэлээ базаав.”

Баригдаж дууссанаасаа хойш арваадхан жилийн дараа л Хархорумын нэр Европын ном судруудад анхлан дурдагдаж эхэлсэн байдаг. 1246 онд Францискийн урсгалын ламтан Г. Плано де Карпини Монгол газар “Хархорум хэмээх нэртэй ганц хот”-оос өөр хот, суурин гэхээр юм байхгүй, “түүнийг нь харин тун аятайхан хот гэгцээдэг” хэмээн бичиж үлдээсэн байна. Энэхүү Карпини, мөн Хархорумыг татаарчууд уугуул нутгаасаа тасран

гүрснаасаа хойш байгуулсан анхны хот хэмээн нэрлэж байсан Марко Поло нарын аль аль нь Хархорум хотод хэзээ ч очиж үзээгүй бөгөөд зөвхөн хүмүүсийн аман ярианаас л мэдээлэлтэй болсон ажээ. Карпинигаас хойш хэдхэн жилийн дараа түүнтэй шүтлэг нэгт Вильхельм фон Рубрук гэдэг фламандер хүн Ариун Дөнисээс Хархорум хотноо хүрэлцэн ирсэн ажгуу. Рубрук гэлэн XIII зууны дунд үеийн Хархорум хотыг орд харш, засаг захиргааны байшин барилгуудтай, худалдааны болон олон улс орны амбан сайдын төлөөлөгчийн газартай, худалдаа наймааны захууд, гар үйлдвэр бүхий космополит буюу олон соёл зэрэгцсэн дэлхийн хот хэмээн тодорхойлжээ. Персийн түүхчдийн үлдээсэн баримт тэмдэглэл ч мөн үүнийг давхар нотолно. Шашин шүтлэгийн эрх чөлөөний энэхүү хотод хүн бүр хүссэнээрээ л шүтлэгийн зан үйлээ гүйцэлдүүлж болдог. Рубрук бичихдээ, “янз бүрийн үндэстний арван хоёр мөргөлийн сүм” байдгаас “хоёр нь Лалын шашны, нэг нь Христосын шашны, нэг нь Несторян шашных” хэмээсэн байна. Монголын Их Эзэнт гүрний нийслэл хотын хувьд Хархорум нь эзэнт гүрний харьяа ард түмнүүд болон тэдгээрийн соёлын амьдралын халуун цэг нь байж, үндэстэн угсаатнууд, соёлын болон шашин шүтлэгийн олон урсгалыг өөртөө агуулж байсан нь Төв Азийн дундад зууны ертөнцийн тухайд дахин давтагдашгүй онцлог төвлөрөл байсан юм. Аливаа шинэлэг, таньж мэдэхгүй юм бүхэнд туйлын нээлттэй, хүлээцтэй ханддаг Монголын хаадын хичээл зүтгэлээр Хархорум хот нь XIII-XIV зууны элдэв төрлийн соёл, цаг хугацааны урсгалуудын хайлмаг болж чаджээ.

1260 онд Хубилай хаан ширээг хууль бусаар булаан авч, өөрийнхөө нийслэл хотыг эхлээд Шанду, дараа нь 1267 онд Да-ду (Бээжин) руу нүүлгэн шилжүүлэв. Ингэснээр Хархорум хот улс төрийн эрх мэдлээ алдаж, түүнээ дагаад ач холбогдол нь ч аяндаа буурлаа. Хархорум ийнхүү ариун шүтээний газраас эхлээд гар үйлдвэрийн хот болох мэтээр явсаар гүйцэтгэх үүрэг нь ч хувьсан өөрчлөгдсөөр байв. Засаг захиргааны хувьд Хархорум нь эзэн хаант Юань гүрний нэгэн хязгаарын буюу “Уулын чанад дахь умард муж”-ийн, үнэн чанартаа (de facto) бол Монголын нийслэл, хожмоо дэд хаан буюу үндсэндээ хаан ширээг хууль ёсоор залгамжлагчийн алба төвлөрөн суух газар болжээ. XIII зууны сүүлийн арав гаруй жилд өрнөсөн монгол ах дүү нарын хоорондын дайн буюу “war

of restoration"-ын үеэр энэхүү хотод өөрийн мэдлээ тогтоохын төлөө ширүүн тэмцэл нэг бус удаа өрнөснөөр хотын нэгээхэн хэсгийг түйвээн сүйтгэв. Өгэдэйн ач хүү Хайду болон Тулуйн удмын Юань гүрний хаадуудын хооронд зөрчил тэмцэл өрнөсөн он жилүүдэд (1277-1301 он) Хархорум хотыг тэд ээлж дараалан эрхшээлдээ оруулсаар, хот ч үймээн самууны хөлд талхлагдсаар, эцэстээ эдийн засгийн хувьд тамирдан суларсан нь лавтай. Гэхдээ Хархорум хот тэгтлээ доройтон мөхсөн нь дайн дажинтай л холбоотой юм. Түүнийг аяндаа ядуурч, үгүйрэн хоосорсон мэтээр хавтгайруулан ярих буруу, ингэж ярих нь тухайн цаг үеийн мэдээ сурвалж, археологийн олдворуудын аль алинтай нийцэхгүй байгаа. Ямартай ч Хубилай хааныг таалал төгссөнөөс хойш (1294 он) Хархорум хот эргэн сэргэх хандлагатай болж, Бээжин хотноо захиран сууж байсан Юань гүрний Эзэн хааны анхаарал халамжийг илүү ихээр татах болов: зөвхөн Төв Азийн нүүдэлчдийн хууль ёсны жигүүрийнхэн төдийгүй, мөн Юань гүрний эзэн хаад ч Хархорумыг Чингис хааны хот, "Хоёр ариун шүтээний" (Өгэдэй хаан, Мөнх хаан) хот хэмээн үздэг байлаа. Тэр бүү хэл "Юань Улсын түүх"-энд өгүүлснээр 1299 онд хотыг үргэлжлүүлэн барьж, зүүн тийш нь бололтой өргөтгөн тэлжээ. Дайн дуусаад хоёрхон үе өнгөрсний хойно 1346 оны бичээст хотыг "агуу/хүчирхэг нийслэл [Хархорум] хотын гайхамшигтай (ганган хээнцэр) дүр төрх" хэмээн магтан дуулсан байдаг.

Өгэдэй, Мөнх хааны үед баригдаж дууссан, Юань гүрэндээ хамгийн томд тооцогдож байсан гэгдэх аварга том суварган сүмийг 1311 онд анх удаа сэргээн засварлах ажилд маш их хөрөнгө зарцуулсан бөгөөд Эзэн хаан өөрөө энэ бүх зардлыг гаргав. Мөн үүнээс хавьгүй илүү өртөг зардал шаардсан хоёр дахь удаагийн сэргээн засварлах ажлыг ч хаан эзний тушаал заавар, санхүүжилтээр гүйцэтгэжээ. Дуганыг засварлах ажил дөрвөн жил үргэлжилсний эцэст (1342-1346 он) Эзэн хааны хүслээр түүнийг "Юань гүрний эхэн үеийн асар" хэмээн нэрлэх болов. Эдгээрийг хийж бүтээсэн барилгачид, шаазан эдлэлийн урчууд, уран зураач, барималчид Аль-Умарийн бичсэнчлэн "... хүн амынх нь дотор гайхалтай уран гартнууд, урчууд байдаг" тус хотын өөрийнх нь оршин суугчид байсан бололтой. Мамлюкуудын засаг захиргаанд дээгүүр алба

хавшиж байсан түшмэл Аль-Умари хэмээх энэ сири хүн 1340 онд Хархорум хотыг дүрслэн бичихдээ:

"... гайхамшигтай сайхан хот, Эзэн хааны цэргийн дийлэнх нь байрладаг томоохон хуаран, үнэт гоёмсог сүлжмэл эдлэл, тансаг эд агуурсын төв. Эзэн хааны гар үйлдвэрлэлийн хот хэмээн тооцогддог болохоор ордны хэрэгцээг бараг л дан ганц эндээс хангадаг." гэжээ.

Хархорум нь XIV зууны дунд үе гэхэд Эзэнт гүрний уураг тархи байхаа хэдийн больсон авч дийлэнх монголчуудын хувьд үзэл суртлынх нь төв гэдэг утгаа хадгалсаар байсан нь илэрхий. үүний тод жишээ бол өмнө нь ямар ч нэр усгүй байсан дээрх суварган сүмд Эзэн хаан өөрөө биечлэн нэр хайрласан явдал. Энэхүү сүм нь өгсөн нэрээсээ эхлээд л хаан эзнийг тахин шүтэх ёсны дурсгал, Юань гүрний төрийн суртал нэвтрүүлэг болж байсан бололтой байна. 1346 оны бичээст, "Хаан эзэнт гүрний бүхий л сүм хийдүүдээс түүнтэй эн зэрэгцэх нь үнэхээрийн үгүй" хэмээжээ. Мөнхүү бичээст Эзэн хаан өөрөө Хархорум хотыг монголчуудын үзэл суртлын нийслэл хот байсныг ч хүлээн зөвшөөрч, "энэ бол манай Эзэнт гүрэн (Юань Улсыг хэлж байна) анх үүссэн газар мөн болой" гэсэн байдаг.

Юань гүрний сүүлчийн Эзэн хаан Тогоонтөмөр 1368 онд Бээжингээс Өвөр Монголын Инчан (Jehol) руу дүрвэн зугтаж, 1370 онд тэндээ нас эцэслэв. Түүний хүү, хаан ширээг залгамжлагч хан хүү Аюуширидарын орд өргөө Хархорумд байрлаж байжээ. 2001 онд Юань гүрний Эзэн хаадын угсааныхны нэг болох түүний нэрийг сийлсэн тамгыг хотын төв хэсэгт Бонны Их Сургуулийнхны хийсэн малтлагаар олж илрүүлсэн нь Их Эзэнт гүрний төрийн тамга байв. 1370 онд Хархорумын Хуралдайгаас Билигтийг хаан оронд суулгах шийдвэр гаргаснаар Хархорум хот ахин нэг удаа Монголын уугуул эзэнт улсын буюу "Ар Юань"-ий нийслэл хот болон хувирчээ.

1378 онд Билигт хаан тэнгэрт хальснаас хойно л Хятадын цэргүүд монголчуудыг Хятадаас бүрмөсөн хөөн зайлуулж чадсан юм. Эцэстээ 1388 онд Монголын их цэрэг бут ниргэгдэж, Хархорум

хотыг Мин улсын Сүй генералын цэрэг эвдэн сүйтгэсэн бололтой байна. Хархорум хотод юутай ч XVI зууны эхэн гэхэд амьдрал өрнөсөн хэвээр байсан, эсвэл эргээд сэргэсэн болов уу гэлтэй. Учир нь Хархорумыг XVI зууны эхэн үеэр хамгийн сүүлчийн удаа нийслэл хот болгон өргөмжилжээ. Гэвч тус хотын мөхлийг зогсоох ямар ч арга байсангүй. Хархорум аажимдаа эзгүйрэн хаягдаж, 1580-аад оны орчим бүрмөсөн төгсгөлдөө ирэв. Умарын халх монголчуудын анхны эзэн хаан Автай хан 1585-1586 онуудад орхигдсон хотын өмнөд хязгаарт Эрдэнэ зуу хийдийн анхны сүм, дугануудыг бариулсан байна. Хийдийг барьж босгоход хуучин нийслэл хотын үлдэгдэл материалыг үлэмжхэн ашигласан ба ийм үлдэгдлийн тоонд чулуун дээр сийлсэн бичээсүүд, тухайлбал 2003 онд "Их хуралдааны хийд"-ийн суурины малтлагаар бидэнд олдсон 1346 оны хятад-монгол бичээс бүхий чулуун хөшөөний хэлтэрхий мөн орно. Уг чулуун хөшөөний хятадаар сийлсэн тал дээр Хархорумыг анх үүсгэн байгуулсан он цагийг "Тайзугийн [Чингис хааны] 15-р он буюу луу жил ..." хэмээн заасан байгаа.

2000 оны 7-р сараас Германы археологичид Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэнтэй нягт хамтран ажиллаж, эртний Монгол Улсын нийслэл Хархорум хотын нууцад нэвтрэн орох түлхүүр хэсгүүдэд малтлага хийж байна. Малтлагын ажлуудыг чиглэсэн тодорхой зорилготойгоор явуулж, хотын түүх, мөн Монголын Их Эзэнт гүрний түүх болон олон улс үндэстний соёлтой холбогдох шинэ шинэ эх сурвалж олж авахыг зорьсон болно.

Нордрайн-Вэстфаллень муж болон ХБНГУ-ын Боловсрол, Судалгааны яамны хөрөнгөөр санхүүжигдсэн Бонн хотын Их Сургуулийн төслийн баг гол төлөв хотын төв хэсэгт, Хятадын дүүргийнх ("Катай дүүрэг") байсан болов уу гэмээр орон сууцны барилгууд болон гар үйлдвэрийн газрууд даган байрлах хотын гол гудамжны дагуу бага бага хэсэгчилсэн малтлага хийсэн бол, Германы Эрдмийн Солилцооны Алба (DAAD)-ны дэмжлэг, 2003 оноос Германы Судалгааны Нийгэмлэгийн (DFG) санхүүжилттэйгээр Германы Археологийн Хүрээлэнгээс явуулж буй малтлагын ажлууд (хотын баруун өмнөд хэсэг дэх) "Эзэн хааны ордны дүүрэг" гэдгийн ойр орчимд тусгайлан сонгосон газруудад

шилгэж байна. Уг хоёр төслийг 1998 онд албан ёсоор байгуулагдсан Монгол-Германы хамтарсан Хархорумын шинжилгээний ангийн дэвнэр дор нэгтгэсэн бөгөөд 2000 оны 5-р сард "Монгол Улсын түүх, археологийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааны хүмүүд дээрх төсөл ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж, Герман-Монголын харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор" тус шинжилгээний ангийг Монгол Улсын Ерөнхийлөгч, ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч нар өөрсдийн ивээл дор авсан билээ.

1948 онд С. Киселевоор удирдуулсан Зөвлөлт-Монголын хамтарсан шинжилгээний анги хотын төвд байрлах "гудамжуудын үүлзвар дээрх барилга" гэдгийг малтан гаргаж ирсэн бөгөөд хотын төв хэсгийн хөрсний доорх давхаргуудын зузаан, тэдгээрийн тогтцоос үзэхэд хотын ерөнхий түүхийг газрын доорх үелсэн давхаргаар нь хөөн тогтоох хамгийн боломжтой мэт санагдаж байв. Үүнээс гадна Киселевын явуулсан малтлагын үр дүн юуны өмнө хотын умард, өмнийг холбосон гол замын дэргэдэх малтлага хийсэн мөнхүү талбайгаас зүүн тийшээгээ, Хятадын дүүрэг байсан байж магадгүй тэр хэсэгт ордны түшмэдүүдийн орон сууцны байшингууд, гар урлалын газрууд хоорондоо маш нягт шахцалдан байрлаж байжээ хэмээн таамаглахад хүргэлээ. Тиймийн учир хөрсний үе давхаргын зузаанаар он дарааллыг судлан тогтоохын зэрэгцээ хотын энэ хэсэгт, "дээдэс хийгээд барлагууд, баячууд хийгээд ядуус" (Рашид ад-Дин)-аас бүрдсэн Хархорум хотын олон янзын соёлтой, нийгмийн талаасаа ч гэсэн өөр хоорондоо нэлээд ялгаатай байж болох хүн амын материалаг соёлыг олон үндэстэн угсаатны төлөөлөл дунд нь судлах боломж ч гарч ирж байна. Боннын Их Сургуулийнхны хийсэн малтлагын ажлууд энэ бүхнийг дорвитойхон хэмжээнд нотолж чадсан юм.

Асар зузаан үе давхаргууд бүхий хөрсний нэлээд гүн хэсэгт хийсэн нэгэн малтлагаар хэд хэдэн үеийнхний барилга байшингийн үлдэгдлийг олж тогтоосон бөгөөд археологч Э. Пооль эдгээрийг дараалсан 4-5 залгамж үеийнхний суурьшлын ул мөр гэж тодорхойлов. Ялангуяа Хархорум хотын нутаг дэвсгэрийг бараг л тэнцүүхэн хоёр хэсэгт хувааж асан, умраас өмнийг чиглэсэн хамгийн том төв гудамжийг олж илрүүлсэн явдал маш чухал ач холбогдолтой юм. Худалдаа наймаа, зам тээврийн хөдөлгөөн нь

хайрган дэвсгэр дээр шохойн чулуун хавтан дэвсэж зассан маш тохилог зам, талбай дээр тасралтгүй өрнөдөг байжээ. Ийм маягийн гудамжийг хот анх үүсэн байгуулагдаж байсан үе буюу XIII зууны эхний хагас гэхэд хэдийнээ хийчихсэн байсан гээд бодохоор тус хотыг байгуулахдаа бүр анхнаас нь л сайтар бодож төлөвлөж байсныг тодхон харуулж буй хэрэг юм. Уг гудамжийг, түүнийг дагуулан барьсан бусад байшин барилгын адил бараг хоёр зууны туршид хэд хэдэн удаа сэргээн засварлаж, техник төхөөрөмжийг нь өөрчилж байжээ.

Төрөл бүрийн материал боловсруулж байсан олон тооны задгай галын ором, зуухнууд нь хотын энэ дүүрэгт гар урлалын үйлдвэрлэл чамгүй эрчимтэй хөгжиж байсныг илтгэнэ. Хотын төв хэсэгт хийсэн малтлагаар, Рубрукийн бичиж үлдээсэнчлэн катай (cathai) нарын буюу "дан гар урчуудаас бүрдсэн" умрын хятадуудын дүүрэгтэй таарсан гэж Пооль үзэж байна. Хятадаас оруулж ирсэн маш олон шаазан ваар эдлэл, бусад бараа бүтээгдэхүүн тэндээс олдсон нь хятадуудын дүүрэг байсныг нэг талаас нотлох авч, нөгөө талаар энгийн гар урчуудынхаас хавьгүй өндөр түвшний хэрэглээ бүхий бүлгийнхэн энд амьдарч байсныг харуулж байж ч болох мэт. Баян чинээлэг түшмэдүүд болон худалдаачид гар урлалын үйлдвэрүүдтэй шууд хаяа хатган амьдарцааж байсан бололтой. Зөвхөн хотын төвөөс л гэхэд 300 орчим хятадын зоос олдсон нь мөнгөн гүйлгээ нэлээд тогтож хэвшсэн байсныг гэрчилнэ. Төв Азийн мөнгөн зоосууд, тэдгээрийн дотор зоосны домог түүхэнд Хархорум хэмээх нэрээр тэмдэглэгдэн үлдсэн, өөрийн гэсэн нэр, он тооллын бичээс бүхий хамгийн эртний олдвор болох 1237 оны мөнгөн зоос уг хот анхнаасаа л тив дамнасан худалдааны өргөн хэлхээ холбоотой байсныг илтгэн харуулна. Гар урлал, худалдаа наймааны үйл ажиллагаа XIV зууны хоёрдугаар хагас хүртэл байнга үргэлжилсээр байсныг нотолж болохоор байна. Хархорумын хожуу үеийн түүхэнд хамаарах тодорхой он цагийг илэрхийлсэн хамгийн чухал гэрч баримтуудын нэг бол тухайн үеийн Сангийн яамны тамга буюу дээр дурдагдаад өнгөрсөн 1371 оны Аюуширадарагийн тамга юм.

Эрдэнэзуу хийдийн умарт хэсэгт байрлах сөнөсөн хотын туурь Монголын нийслэл Хархорум хот мөн эсэх талаар 100 гаруй

жилийн тэртээгээс өрнөөд байгаа маргаанд Хааны ордон нэг бус удаа шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байсан юм. Оросын судлаач Сергей Киселев ч гэсэн Рубрукийн тэмдэглэлд гардаг Хааны ордныг археологийн малтлагаар олоод илрүүлчихвэл Монголын Хархорумын байршлын талаар одоо хүртэл үргэлжилсээр буй маргаанд нэг мөсөн цэг тавина гэдэгт итгэдэг байлаа. Эрдэнэ луугаас умард зүгт байрлах нэгэн суурины үлдэгдлийг дөнгөж XIX зууны эцэс гэхэд нээн илрүүлээд, түүнийгээ эртний "Монголын Хархорум" (Вилхельм Радлов) хот хэмээн үзжээ. үүнийг анх нээн илрүүлсэн хүнийг Оросын Н. В. Ядринцев гэж үздэг бөгөөд тэрбээр хамгийн анх 1889 оны 7-р сард, сөнөсөн балгасын тархан байрласан туурийг даган явсаар Монголын Хархорум болохыг таньж чадсан байна. Ядринцев тус газрын байрлалыг нутаг орны топографийн байдалтай харьцуулан судалж, Эрдэнэ зуу хийдийн тайлбардээрээс олдсон Хархорумын чулуун хөшөөний бичээсүүдээс үлдэж хоцорсон олдворуудад тулгуурлан энэхүү дүгнэлтээ гарган авсан аж. Бүр 1877 онд Оросын монголч эрдэмтэн А. Позднеев Эрдэнэ зуу хийдэд хүрэлцэн ирснээсээ хойш хийдийг хүрээлсэн ханан хэрмийг эртний Хархорумыг хүрээлж байсан хана мөн гэх болжээ. Хархорумын анхны план зургийг хийсэн гавьяа түрэг судлаач, Орхоны хөндийг судлах Оросын шинжилгээний ангийн ажлагч, Берлин хотын уугуул Вилгельм Радловт ноогдоно. Түүний 1892 онд анх бүтээсэн "Монголын эртний түүхийн атлас" Монголын археологийн шинжлэх ухааны үндсийг тавьсан бахдам үйл явдал болов. Уг бүтээлийнхээ "Эрдэнэ зуу хийдийн (эртний Хааны ордны) план зураг" нэртэй 36-р нүүрний тайлбар хэсэгт Харум хотын бэлгэдэл болох аварга том боржин чулуун яст мэлхийний тухай Радлов, "[энэхүү] яст мэлхий нь ... эртний хотын туурины хажууд маш өндөр овоолсон цөөн хэдэч шороон овгоруудын үрд байрлана" хэмээн хэдхэн үгээр тэмдэглэсэн байдаг. Эдгээр "туурь"-ийг тэрээр зургийн тайлбартаа "китайский город" гэж нэрлэсэн байдаг ба энэ нь цэвэр үгийнхээ утгаар "хятадуудын хот" гэсэн үг, харин дам утгаараа бол мөн арилжаа наймааны болон үйлдвэр үйлчилгээний дүүргийг нэрлэдэг хоёрдмол агуулгатай ойлголт юм.

"Өндөр шороон овгорууд", өөрөөр хэлбэл яст мэлхий ойролцоох орон сууцнууд байрлаж байсан тэдгээр догнууд дунд л Эзэн

хааны ордон байх ёстой хэмээн анх удаа таамагласан хүн бол Австрийн амьтан судлаач Ханс Ледер юм. 1892 онд Ледер Эрдэнэ зууд ирж үзэхдээ хийдийн умард хэсэгт “намхан хана, суваг шуудуу, өндөрлөсөн газар мэтийн үлдэгдлээс тогтсон янз бүрийн нуранги, овоолгууд нь яах аргагүй хүмүүс амьдарч байсан суурин газар, орон сууц байсны шинж тэмдэг мөн...” болохыг олж хараад, “Монголын Эзэн хаадын ордон нь хийд болон түүний эргэн тойрны хана хэрмээс хойшоогоо буун сум хүрэх зайнаас холгүй газарт байрлаж байх ёстой гэдэг бодлоосоо салж чадахгүй” байгаа тухайгаа өгүүлсэн байдаг.

Нээрээ ч Хархорумын талбайн дэвсгэр зураг дээр хотын дотор эргэн тойрон зааглагдсан нэгэн дүүрэг мэдэгдэхүйц ялгаран харагддаг бөгөөд энэхүү дүүрэг нь хана, хаалга, байшин барилгын сайтар хийсэн суурь бүхий нэг ёсондоо хотын доторх хот билээ. Хотын баруун өмнөд захын барилга байгууламжийн цогцолборын суурийг хамгийн анх удаа малтаж үзсэн Сергей Киселев хэмээх орос хүн 1949 онд уг цогцолборыг “Хааны ордны дүүрэг” хэмээгээд тэрхүү дүүргийн тэхий голоор сунаж байрласан овгор нурууг Хааны ордон мөн хэмээн тогтоожээ. Түүний таамаглал нь юуны өмнө Вилхельм фон Рубрукийн Хааны ордны тухай тухайн үедээ бичиж үлдээсэн тэмдэглэл дээр тулгуурлаж байв. Түүгээр бол ордны дүүрэг (латинаар: *sigta*) хотын хамгийн баруун, эсвэл баруун өмнө захад байрлаж асан байж тун магадгүйн дээр ордон нь өөрөө гурав, эсвэл таван том танхимд хуваагдсан байх учиртай аж.

“Мөнх хаан Хархорум хотын ханан хэрмийн хажууханд (дэргэд, латинаар: *iuxta*) Хааны том ордонтой, түүнийг нь зузаан тоосгон хэрмээр хүрээлсэн байдаг ... энд нэгэн том ордон буй. [...] Хааны ордон нь сүмийн байшин мэт дундаа нэг том, хажуу талдаа хоёр танхимтай бөгөөд тэдгээр нь хоёр эгнээ баганын завсар оршино. өмнө талдаа гурван хаалгатай.” Ордны дүүргийн дотор “агуулах сав мэт урт урт барилга байшин байх агаад эдгээрт хоол хүнс, үнэ цэнэтэй эд агуурсыг хадгална.”

Рубрукийн тэмдэглэснээр бол Хааны ордон нь хотын баруун буюу баруун өмнөд хэсэгт Орхон гол руугаа чиглэн байрласан

байж таарч байгаа юм. Учир нь, “зуны улиралд хотын дундуур хаа сайгүй хиймэл горхи урсган хотыг усалдаг” гэжээ. Ордны байрлалын талаарх энэ тодорхойлолт Киселевийнхээр бол Хархорум хотын баруун хананы дагуу байрлах, хотоос тусгай хана хэрмээр тусгаарлагдсан баруун өмнөд дүүргийн хувьд л зонхон тохирох аж. Ийнхүү Сергей Киселевын удирдсан Зөвлөлт-Монголын хамтарсан шинжилгээний ангийн археологичид 1949 оны зун Ван-ань ордон буюу Өгэдэй хааны ордныг олсон гэдэгтээ итгэлтэй байжээ.

Ордны топографийн байршлыг тодорхойлохдоо Киселев археологийн олдворууд дээр түшиглэсэн хэмээн үзжээ. Ийнхүү гэрбээр, 1949 онд хийсэн Хааны ордны малтлагаар олдсон барилгын эд зүйлс нь уг ордны талаар Вилхельм фон Рубрукийн тодорхойлсонтой яг таарч буй тул түүний ухаж гаргаж ирсэн баганат танхим нь Өгэдэй болон Мөнх хааны ордон гэдэгт эргэлзэх хэрэггүй гэж байв. Түүнийхээр бол хотын хана хэрэмд түгж ирсэн ордны цогцолбор гээд байгаагийн зах хязгаарын байрлал нь ч гэсэн Рубрукийн бичсэнтэй ижил, түүнээс гадна Персийн түүхч Жувейнигийн тэмдэглэлтэй ч мөн тохирч байгаа аж. “Юань Улсын түүх”-нд тэмдэглэн үлдээснээр энэхүү ордныг хятад маягийн ордны цогцолбор байсан хэмээн үзэх учиртай юм. Учир нь ордны зураг төслийг хятад архитекторч гаргаж, Умард Хятадын урчууд түүнийг барьж босгожээ. Үнэхээр ч энэ дүүрэг дэх байшин барилгын байрлалыг харахад хятадын загвараар барьсан ордны хотхон мэт санагдана. Киселевын үзэж буйгаар газар дээр ил харагдаж буй Төв ордны суурь, хажуугийн таван байшингийн суурь, тэдгээрийг хүрээлсэн хана хэрэм болон хэрмийн хаалга зэрэг нь цогцолбороороо нийлээд Хятадын ордны сонгомол загвараар бүтээгдсэн агаад Рубрукийн аян замын тэмдэглэлд ч, Персийн түүхчдийн бичсэн зүйлд ч ингэж л тодорхойлсон байдаг гэнэ. Хайрга, элс, шаврыг ээлжлэн давхарлаж хийсэн, гурван метр шахам өндөртэй асар зузаан шороон суурь, түүний дээрх хэд хэдэн тасалгаанаас бүрдсэн асар том танхимын үлдэгдэл, боржин чулуугаар хийсэн том том баганат суурь, дотогшоо цөмрөн нурсан, ногоон өнгийн паалан бүхий ваарандээвэр, мөндээврийн чимэглэл болох луу, арслан зэргийг Киселев ордны барилга байгуулалтыг год харуулж буй баримт, 1235-36 онд баригдсан хааны ордны

барилгаас үлдэж хоцорсон зүйлс болох нь эргэлзээгүй хэмээн үзсэн байдаг юм. Энэ үндсэн дээр Ядринцевийн нээн илрүүлсэн Хархорум нь монголчуудын Хархорум мөн гэдэг нь Киселевын хувьд бүрмөсөн батлагдсан юм санжээ.

Киселев, түүний хамтран ажиллагсад дараалсан гурван өөр цаг хугацаанд баригдсан буюу гурван үеийн барилга байшин - хамгийн доор нь ордон барихаас өмнөх буюу XI-XII зууны үеийн Бүддийн шашинт монголчуудаас өмнөх үе, түүний дээр хоёр дахь буюу XIII зууны барилгын суурь болон ордны Их танхим бүхий Эзэн хааны ордны үе, хамгийн дээд талд барилгын гурав дахь үе буюу XVII-XIX зууны "хийдийн үе", өөрөөр хэлбэл Ордны буурин дээр барьсан Бүддийн шашны дуган бүхий "Эрдэн зуу хийдийн үе"-ийг илрүүлээ хэмээн итгэж байв. Киселевын гаргаж ирсэн "Ордны өмнөх үе - Ордны үе - Сүм хийдийн үе" хэмээх гурван шатлалын загвартай өнөөг хүртэл нэг ч судлаач сэргэлдэж байсангүй, түүний нотолгоонуудыг ямар ч хөдөлбөргүйд тооцсоор иржээ.

Харин Х.-Г. Хюттель, Д. Баяр, К. Франкен нарын удирдсан Монгол-Германы хамтарсан Хархорумын шинжилгээний багийнхны "Ордны дүүрэг"-т хийсэн судалгаагаар энэ нь үндсээрээ өөрчлөгдлөө. Германы Археологийн Хүрээлэнгийн (DAI) харьяа Европын бус Соёлын Археологийн Комисс (КААК)-ын хийсэн Ордны малтлагууд тус Ордны талаар өнөөдрийг хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөөр ирсэн Киселевын тайлбаруудыг туйлын эргэлзээтэй болгов. 2001-2003 онд хийсэн малтлагаар ил гаргаж ирсэн Ордны Их танхимыг малтлагын хамгийн сүүлийн үеийн үр дүнд тулгуурлан цоо шинээр тодорхойлох ёстой боллоо. Өдгөө бид энэхүү "Их танхим" нь Ван-ань ордны юм уу Хааны ордонтой холбоотой ямар нэг ёслол хүндэтгэлийн барилгын хүлээн авалтын их танхим ч биш төдийгүй, ерөөс өөр ямар нэгэн ордны танхим байх магадлал багатай гэдгийг иш үндэс болгож байна. Уг барилгын археологийн малтлагын дүнгээс үзвэл энэхүү Их танхимыг анхнаасаа л Бүддийн шашны дуган байхаар төлөвлөн босгосон гэх нь үнэнд илүү ойрхон агаад XIV зууны сүүл хэрд эвдэн сүйтгэгдэх хүртлээ Бүддийн шашинтны шүтээний газар хэвээр байжээ. Сүм-суварга хэмээн таамаглаж буй энэ барилга хийц хэлбэрээрээ ч тэр, мөн тухайн цаг үед, тэр тусмаа Хятадын

Барилга байгууламжид огт хэрэглэдэггүй байсан 7x7 йох (буюу 6x6 багана) гэсэн хачирхалтай хэмжээ, тэрчлэн өрөө танхимын зулаарилалт, баримлын чуулган зэрэг нарийн ширийн зүйлсээрээ ч 1346 оны Хархорумын чулуун хөшөөний бичээст гардаг "Юань гүрний эхэн үеийн [Бүддийн шашны] асар"-тай мэдэгдэхүйц төстэй байгаа юм. Уг асрын доод хэсгийн байгууламж, өөрөөр хэлбэл өндөрлөн зассан тавцан болон суурийг Өгэдэй хааны үед (1229-1241) байгуулсан бол дээр нь барьсан барилгыг бүр Мөнх хааны үед 1256 онд дуусгасан ажээ.

"Их танхимын" орчимд хийсэн бидний малтлага Киселевын дэвшүүлсэн гурван үет шаттайгаар түүхчилсэн таамгийг няцааж байгаа бөгөөд ер нь цаашдаа үүнийг баримтлах боломжгүй болж байна. Хотын барилга байгууламжийн түүх гурван үе шаттайгаар явагдсан гэх түүний таамаглал нэг ч олдвороор нотлогдоогүй ба харин ч нэлээд зүйлсийг эндүү ташаа ойлгож явсан нь олон тооны олдворууд дээр тов тодорхой харагдав. Киселевын хожмоо хамгийн их уршиг дагуулсан томоохон эндүүрлүүдийн нэгийг бид 2004 онд мөнхүү танхимын умард захад, ордны 6000 куб метр эзэлхүүнтэй нүсэр том сууринд хөндлөн огтлолын дагуу хийсэн малтлагаар олж тогтоосон болно. Тэрхүү хөндлөн огтлолын талбайд 1949 оны Орос-Монголын багийнхны хийсэн малтлагын хайгуулын шуудууны ерөнхий хэлбэрийг харуулсан ором тодорхой харагдаж байлаа. Чингэтэл Киселев энэ хэсэгт түүний өөрийнх нь болон Мерпертийн нотлон өгүүлээд байсан шиг доорх газарт нь тултал яавч малтаагүй болох нь тогтоогдоод ирэв. Орос-Монголын хамтарсан хайгуулын малтлага Киселевын үзэж байсан шиг суурийн доод газарт, өөрөөр хэлбэл Ордон байсан гэж таамагласан тэр газраасаа доош тултал яваагүй нь илэрхий байсан юм. Киселевын малтлагаа зогсоосон газраас суурийн доорх хайрган хөрс хүртэл даруй нэг метр гаруй зайтай байв. Барилгын суурь нь Киселевын ухсан цооногоос доошоогоо нэг метр гаруй зайд үргэлжилж, тэр бүү хэл зарим газарт доорх дөрөвдэгч галавын үеийн хайрган ул хөрс рүүгээ 70 см хүртэл гүн нэвтэрсэн аж. Ордон барихаас өмнөх үеийнх гээд байсан, Бүддийн шашны шүтээний танхимыг хүрээлсэн хана хэрэм уг суурийн өөрийнх нь гаднах хашлага болох нь хөрсний үе давхаргын судалгааны дүнгээр гарцаагүй нотлогдсон болно. Энэхүү хана хэрэм хийгээд

суурийн доор байгаа гэх барилгын үлдцийг Ордны өмнөх буюу XI-XII зууны үеийн Бүддийн шашны шүтээний газрын үлдэгдэл гэдэгт Киселев итгэж байсан нь түүний ноцтой эндүүрэл юм. Уг танхимын умард хэсгээс олдсон ханын зургуудын 40 гаруй тасархайг ч тэрээр тухайн үедээ энэхүү Шүтээний танхимд хамааруулан үзэж байв. Гэтэл бидний хийсэн үе давхаргын судалгаагаар шүтээний ийм танхим байгаагүй болж таарч байна. 1949 оны малтлагаар гарч ирсэн ханын зургуудыг уг тахилын танхимаас өөрөөс нь олдсон Бүддийн шашны уран зураг, баримлын олон тооны үлдэгдэлтэй уялдуулан авч үзэх нь зүйд илүүтэй нийцнэ. Шинээр олдсон цөөвтөр тооны уран зургийн олдворууд будаг, хэв маягаараа 1949 онд олдсон ханын зургийн үлдэгдлүүдтэй тохирч байгаа тул тэдгээрийг нэг үед бүтээсэн гэж болохоор байна. Үе давхаргын судлалын үүднээс хийсэн ажиглалтууд, хэв маягийг тогтоох шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан уг танхимын ханын зургийн тасархайнууд, түүнчлэн шавраар товойлгон урласан ханын чимэглэл болон Бүддийн шашны холбогдолтой том том баримлын олон тооны үлдэгдлүүд, мөн 3 метрээс дээш өндөртэй Бурхан багш хийгээд Бүддийн шашны бусад баримлуудын үлдцүүдийг ч нэгэн адил Ордон байсан үеийнх гэж үзэх учиртай юм.

Одоогийн байдлаар бидэнд хүний биеийн хэмжээтэй шавар бурхан хэд хэд, хүний биенээс хавьгүй том, гурваас таван метрийн хооронд янз бүрийн хэмжээний өндөртэй шавар баримал найман ширхэг олдоод байна. Эдгээрийн дийлэнх нь Бурхан багш буюу Авалокитешвараг дүрсэлсэн байх аж. Эндээс олноор олдсон хурууны хэсгүүдээс бурхдын гарын дохио зангааны байрлалууд (мутар), тухайлбал номын хүрдэн, аливаа зүйлийн учир шалтгааныг тайлбарлах, хүслийг гүйцэлдүүлэх, тэрчлэн ивээл даатгалдаа авах, газар шороог хөндөх, бясалгал үйлдэж буйг илэрхийлэх зэрэг түгээмэл дохио зангаануудыг үзэж болно. Бидний хувьд энд тус бүртээ өөрийн гэсэн мутрын зангаа, зүг чиг бүхий, эсвэл суварганы аль нэг талыг, тухайлбал Ами табха (баруун тал/ бясалгал үйлдэж буйг илэрхийлсэн дохио), Амогхасидхи (хойд тал/ ивээл даатгалдаа авахыг илэрхийлсэн дохио), Акшобхиа (зүүн тал/ газар шороо хөндөхийг илтгэсэн дохио), Ратхнасамбхава (өмнөд тал/ хүслийг гүйцэлдүүлэх дохио), Вайрочана (төв дунд буюу зүүн, өмнөд талуудын хооронд/

Номын хүрдэн буюу аливаа зүйлийн учир шалтгааныг тайлбарлах дохио) гэхчилэн ноогдуулсан Бясалгал үйлдэн буй таван Будда (dhyāna-Buddhas) буюу Сансрын таван Будда (Tathagatas)-гаас үлдэж хоцорсон зүйлстэй тааралдах магадлал тун өндөр юм. Энэхүү таамаглалыг хийхдээ танхимын төв хэсэгт хадгалагдан үлдсэн бурхдын хөрөг зураг, ханын чимэглэл байсан бололтой ханан дээр товойлгон урласан Бурхан багшийн (Tathagatas) олон тооны дүрс, зургуудад тулгуурласан болно. Үе давхаргын судалгааны дүн болон малтлагаар олдсон барилгын үлдэгдлээс үзэхэд танхимын гол дахь нэгэн суваргын доод хэсэг, эсвэл түүний умард хэсэгт байрлах бадамлянхуа цэцгийн хэлбэрт өндөрлөсөн суудал мэтийн Кисилевынхоор бол Ордноос хойших хийдийн үед холбогдох Бүддийн шашны дотоод байгууламжууд нь мөн л Ордон байсан үеийн барилгын үе давхаргад хамаарна.

Энэхүү том танхим бүхэлдээ ил гарч ирэхэд суурь нь 37х38 метр талбайтай, 8х8 боржин чулуун баганын сууриар зааглагдсан долоон өрөө (хятадаар: жиан) буюу йохтой тэг дөрвөлжин хэлбэрийн барилга байв. Хархорум судлал эхлээд нэг зуу гаруй жил болсны дараа 2003 оны малтлагаар бүрэн ил гаргаж ирсэн баганат танхим бол цогцолбороор нь малтаж гаргасан анхны, өрөөс Хархорум дахь иж бүрнээр судалж, үндсэн хэлбэрийг нь тодорхойлон баримтжуулж авсан анхны барилга билээ. Цаашдаа бид төвийг сахих үүднээс "Их танхим" хэмээн нэрлэхээр шийдсэн энэхүү цогцолбор нь хэдийгээр эхлээд яс модыг нь зангидаж, 2-3 үелсэн дээвэртэйгээр барьдаг хятад аргаар бүтээгдсэн, хятад хийцийн барилга боловч Хятадын барилга барих уламжлалт аргыг баримталсан байх албагүй юм. Харин уг барилгыг XIII зууны үеийн барилга байгуулалтад гарсан шинэлэг загвараар барьсан гэх нь илүү зохимжтой юм. Суурийн ерөнхий хэлбэрийг нь баримтлан Боннын төвд судлаач К. Х. Эвердингийн үзэж байгаагаар энэхүү байгууламж нь XIII зууны үеийн Сахьяа урсгалынхны гаргаж ирсэн шинэ санааны дагуу баригдсан буюу сахьяа нарын нэг ёсны төгс бүтээгдсэн сүм байсан бөгөөд харин ийм маягийн сүм Төвдөд өөрт нь бол яг энэ загвараараа хэзээ ч баригдаж байгаагүй аж. Баганын тоо нь гэхэд л Бүддийн шашинд түгээмэл байдаг 8х8 байгаа нь уг байгууламж "бурхан шажны" агуулгатай (эсвэл сансар хорвоог бэлэгдэж буй) болохыг илтгэнэ. Энэхүү барилгын хийц

маяг цаашдаа Монголын уран барилгат даацтайхан нөлөөлж, тухайлбал Хархорумын ойролцоох Шанхын хийдэд 1604 онд босгосон сүм, мөн 1770 онд баригдсан (1937 онд нураагдсан) Эрдэнэзуугийн Хурлын гол дуган буюу "Цогчин дуган" зэрэг хожуу үеийн шашны зориулалттай барилга байгууламжуудыг босгохдоо түүнийг төгс үлгэр жишээ хэмээн үзэж, даган дуурайсан гэдэг нь илэрхий. Энэ хоёр барилга хоёулаа ерөнхий хэлбэрээрээ Хархорумын "Их танхим"-тай ижилхэн агаад хоёуланг нь уг танхимын багасгасан загвараар, үгүй ядахдаа түүнээс санаа авч байгуулсан нь илт байна.

Харваас мандалд зориулагдсан болов уу гэлтэй дотор талын шалыг нь олон төрлийн хавтанцар зүйн хийж, явган зам хөндлөн ташуулан тавьсан нь ордны гэхээсээ сүм дуганы шинжийг илүүтэйгээр илэрхийлж буй. Гол тэнхлэгүүдийн огтлолцлын цэг буюу их танхимын яг тэхий дунд туйпуугаар өрж босгосон тэг дөрвөлжин байгууламжийн суурийг (3х3 метр) Киселев анх малтан илрүүлээд XVII-XVIII зууны "хийдийн үе"-д бүтээсэн нэгэн суваргын үлдэгдэл хэмээн бүртгэсэн байна. 2004 онд мөнөөх "Киселевын суварга" дотроос сүм дуганы суурь тавихад өргөдөг тахилын зүйл олдсон юм. Түүнийг хадгалсан байдал уг байгууламж нь суварга болохыг гарцаагүй илэрхийлэх нэгэн чухал элемент мөн болой. Суваргын доод суурийг тойруулан дөрвөн талд нь дөрвөн хэсэг газарт нийтдээ нэг зуун мянга орчим цац, хатаасан болон шатаасан шавраар урласан бурхдын дүрс зэрэг өргөлийн их хэмжээний эд зүйлс хадгалагдан үлдсэн байсныг Киселев мөн л "хийдийн үе"-д хамааруулан үзжээ.

Ордны үеийн байшин барилгын үлдэгдлийг агуулсан давхарга дотроо хэд хэдэн үе шатанд хуваагдах бололтой. Тус барилгыг анх барьснаас нь хойш хэд хэдэн удаа шинэчлэн засварласан болохыг байгалийн ухааны мэдээ баримтууд болон хөрсний үе давхаргад хийсэн хэсэгчилсэн ажиглалтууд харуулж байна. Гэхдээ шалыг өнгөлөн тавьсан хавтанцруудыг янз бүрийн материалаар бүрсэн нь Киселевын баталж байсан шиг барилга байгуулалтын хоёр өөр үеийг илтгэж буй хэрэг биш юм. үе давхарга бүрийг хэд хэдэн удаа нарийвчлан шинжилсэн бидний судалгааны дүнд шалыг өнгөлсөн янз бүрийн хавтанцрууд бүгдээрээ Хааны ордны

үед хийгдсэн болох нь илүүтэй батлагдав. Тэдгээр нь мандал маягаар үйлдвэрлэлийн нэг л аргаар бүтээгдсэн дүрсүүд гэдгийг нотолж болно. Малтлагаар гарч ирсэн Их танхимыг судалсан судалгааны дүнд бид дээрх барилга байгууламж нь цаг хугацааны хүнд нэгдмэл, барилга байгуулалтын нэг л үеийг (!) илэрхийлсэн давхарга болохыг олж мэдсэн бөгөөд түүнээ олон зүйлээр баталгаажуулсан билээ. Хожмын XVII-XVIII зуунд хамаарна гээд байсан Бүддийн шашны холбогдолтой олдворуудын дийлэнх нь Хааны ордны үеийн бусад олдворуудын хамт нэг л дээврийн гоосгон нуранги доорх нэг л давхаргаас олдсон юм. Төвийлгөн хийсэн ханын элбэг баян чимэглэл, Бүддийн шашны холбогдолтой ханын зургууд, Бурхан Бүддагийн янз бүрийн хөдөлгөөнийг илэрхийлж товойлгон урласан баримлууд зэрэг нь нэгэн зэргээр нэг л барилгын хана туургыг чимэглэж байсан аж. Суваргууд, мөн танхимын хойд хэсэгт байрлуулсан лянхуа цэцгэн суудал зэрэг умар ч эргэлзээгүйгээр Бүддийн шашинд холбогдох зүйлсийн аль аль нь Ордны дараах цаг үед хамаарах, дэд зэрэглэлийн байгууламжууд гэдэг нь нотлогдсонгүй. Тэдгээр нь Киселевын итгэж байсанчлан Ордны өмнөх үеэс гаралтай бус, харин яг л шалны хавтанцрууд шигээ Хааны ордонтой нэг үед бүтээгдсэн "мандал"-ын салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд болох нь гарцаагүй юм.

Ордноос өмнөх үеийн шүтээний газар байсан гэж батлагдаагүйн нэгэн адил Ордны дараах үеийн сүм-суварга гэж мөн л батлагдсангүй! Их танхимын ур хийц хийгээд түүний доторх Бүддийн шашны эд өлгийн зүйлсийг бие биеэс нь салангид авч үзэхийн аргагүй юм. Эдгээр нь харьцангуй нэг цаг үеийнх бөгөөд XIII-XIV зууны хооронд бүтээгдсэн болохыг нь олдворуудын байдал ч, байгалийн шинжлэх ухааны үндэстэй мэдээ баримтууд ч харуулж байна. "Ордны дүүрэг" гэдгийн гадна талд ч гэсэн монгол угсаатнаас өмнөх, эсвэл Ордноос хойших үеийн барилга байгууламжийн үлдэц гэхээр зүйлс археологийн малтлагаар өнөө хир нотлогдоогүй, тийм ил олдвор ч гарч ирээгүй байна.

Эндээс олдсон урлагийн бүтээлүүдийн цогц чанар нь барилга байгууламжийн олдворуудынхаа нэгдмэл байдалд бүрнээ нийцэж байгаа юм. Ийнхүү "Их танхим"-ын Бүддийн шашны урлал нь

тухайн үедээ зэрэгцэн оршиж асан бүс нутгийн юм уу, үндэсний хэмжээний онцлогийг илэрхийлэгч наад зах нь гурван янзын урлангийн хэв маягийг нэгтгэн зангидсан "олон улсын" хэмээгдэх цорын ганц том хэв маягийн давхаргыг цогцлоосон байв. Юу гэвэл, Хархорумын баримлын урлагийг бүхэлд нь авч үзвээс ихэвчлэн XII-XIV зууны үеийн Энэтхэг (Непал)-Төвдийн, эсвэл Хятад-Төвдийн хэв маягаар бүтээгдсэн байна. Энэ урлагийн хамгийн ойрын садан нь 1227 онд Чингис хааны цэргүүд довтлон сөнөөсөн Тангудын нийслэл Хар хотын урлаг. 1227 оны довтолгооны үеэр Хар хотоос гар урчуудыг олноор нь олзлон Монголд авчирсан байхыг үгүйсгэх аргагүй юм. Хархорумын Бүддийн шашны холбогдолтой дүрсийн болон чимэглэлийн урлалыг урлагийн түүх талаас нь эцсийн бүлэгт аль ч ангилалд орууллаа гэсэн "Их танхим"-ын Бүддийн шашны эд зүйлс нь тэр аяараа Юань Улсын үеийнх бөгөөд XIV зуунаас хойших үед хамааруулж хэрхэвч болохгүй нь лавтай. Хархорумын "Ордны дүүрэг"-ийн Бүддийн шашны үе гэдэг нь барилга байгуулалтын хийгээд урлагийн түүх талаасаа нэг л зүйл юм. Энэ нь цаг хугацааны хувьд Киселевын "Ордны үе"-тэй мөн тохирно.

Киселевын "Хийдийн үе" гэгч хоосон таамаглал болох нь нотлогдоод байгаа ба Ордон баригдахаас өмнөх XI-XII зууны үед хамаарах "Бүддийн шашны шүтээний газар" гэдэг шигээ огт байгаагүй зүйл болохыг археологийн олдворууд ч, судалгааны дүн ч харуулж буй. Танхимын голд хадгалагдан буй хэдэн арван мянган цац суварга, бурхдын хөрөг зураг нь мөн л Юань гүрний, эсвэл түүнээс өмнөх үед бүтээгдсэн ажээ. Туйлын хэврэг эд гэдэг талаас нь бодсон ч эдгээр нь XVII зуунд хоёр дахь удаагаа хадгалагдан үлдсэн зүйлс, тэр бүү хэл хананд түүхий шавраар товойлгон урласан олон тооны баримал, цац зэргийг өөр газраас шилжүүлэн авчирсан гэх магадлал тун өчүүхэн юм. Эдгээр эд зүйлсийн дийлэнх нь тэнд анх хадгалагдсан чигээрээ л байгаа бөгөөд тухайн үедээ энэ бүхнийг нэг дор бүтээсэн байж ч магадгүй. Хадгалагдан үлдсэн бурхдын хөрөг зураг, товойлгон урласан шавар баримлууд нь хэв маяг, хэмжээ дамжаагаараа тэндээс олдсон ханын зураг, тэрчилэн суварга, гуунууд доторх баримал дүрс, ургамлын чимэглэлтэй ижилхэн байна.

Хөддий үеийнх гэдгийг нь тогтоож болохуйц өргөн сонголт бүхий шатаан ваар эдлэлүүд ч урлагийн хэв маягийнхаа хувьд тодорхой нэг цаг үед (XII-XIV зуун) тохирч байгаа юм. Хааны ордон гэж үзээд байгаа тэрхүү танхим, түүний зэргэлдээ орших байшин барилгууд, мөн олон тооны шатаах зуухан дотроос олдсон эд зүйлс тэр чигээрээ XII-XIV зууны (Сүн Улсаас Юань Улс хүртэл) үеийнх байна. Бүддийн шашинтай холбоотой шавар баримлуудын дийлэнх хэсгийг лавтайяа Хархорумд өөрт нь хийсэн бөгөөд юуны өмнө шатаагаагүй түүхий шавраар товойлгон урласан бүтээлүүдийн хувьд байдал ийм байна. Тэдгээр нь нутгийн урлангуудад хийгдсэн болохыг олон тооны хийц загварууд хийгээд шатаах зуухнаас олдсон олдворууд илтгэдэг. Нэн ялангуяа танхимын дэврийн баримлууд, танхимыг барьсан Бүддийн шашны барилга байгууламжид хэрэглэдэг тэгш өнцөгт хэлбэртэй тоосгонууд зэрэг шатаасан шавар вааран бүтээгдэхүүнүүд нь ордны үед, танхимын баруун өмнө этгээдэд байрлах зуухнуудад шатаагдсан гэдэг нь нотлогдоод байгаа билээ.

2000 оны зуны малтлагаар гаргаж авсан эдгээр шатаах зуухнууд нь Хархорумд хийгдсэн археологийн хамгийн чухал нээлтүүдийн нэг болсон агаад Монгол орны техникийн түүхийн урьд өмнө нь олдож байгаагүй хосгүй дурсгал мөн. Эдгээр нь бүгд нэг тасалгаатай, утаагаа хэвтээ чиглэлд татдаг, өөрөөр хэлбэл хэвтээ байрлалтай зуухнууд юм. Уг зуухнууд нь бүгд гал хөөрөгдөх суваг, гал асаах хөндий, шатаах тасалгаа, задгай галын ам зэрэг бүхий л техник элементүүдийнхээ хамт бараг бүрэн бүтнээрээ хадгалагдан үлдсэн байна. Тэндээс олдсон зүйлс, түүнчилэн бусад барилга байгууламжийн нуранги, овоолго зэрэгт үл хамаарах олдворуудаас үзэхэд, тэдгээр зуухны хоёрт нь барилгын чимэглэлийн зориулалт бүхий дүрсүүд, тухайлбал шавраар луу, арслангийн цуврал дүрс хийж, шатаан бэхжүүлдэг байжээ. Эдгээр нь бүгд нэг гараар, үгүйдээ гэхэд ямар ч байсан нэг урланд хийгдсэн бололтой байна. Энэхүү олдвор нь Дундад зууны үеийн Монголын урлагийн одоо хүртэл бүрхэг хэвээр байгаа түүхэнд хөдөлбөргүй баримт болж байгаагаараа Хархорумын урлангуудаас олдсон бусад олдворуудын нэгэн адил археологичид болон урлагийн түүх судлаачдын хувьд ямар ч алтнаас илүү үнэ цэнтэй зүйл билээ.

Гурав дахь зууханд дээврийн, дөрөв дэхид нь шалны болон ханан хэрмийн тоосгыг шатаадаг байжээ.

Эдгээр зууханд анх тоосго шатааж эхэлсэн нь тэртээ 1235 он уу, эсвэл XIII зууны сүүлч, магадгүй бүр XIV зууны дунд үе үү гэдгийг баттай хэлж хараахан болохооргүй, байж болох хугацаа нь цар хүрээний хувьд XIII зууны эхэн үеэс XIV зууны дунд үеийг хүртэл хамарч байгаа юм. Харин эдгээр зуухны ажиллагааг XIV зууны аль нэг үед зогсоосон гэдэг нь бол баталгаатай зүйл. Байдлаас үзэхэд, ажиллагсад нь зуухнуудаа гэнэт орхин зугтжээ гэсэн сэтгэгдэл төрөхөөр байна. Тэд нар нь тэгээд хэзээ ч буцаж ирээгүй, түүнээс хойш уг зуухнууд хэзээ ч ахин ашиглагдаагүй бололтой юм.

Ордон байсан гэх Киселевын таамаглалыг бодвол сүм байсан гэх бидний таамаглал нь дотооддоо ямар нэг зөрчил агуулаагүй гэхэд болно. Хөрсний үе давхаргын болон барилга байгууламжийн судалгааны дүн, нэн ялангуяа археологийн олдворууд нь энд дор хаяж нэг удаа өөрчлөн зассан, бараг бүхэлдээ Бүддийн шашны эд зүйлсээр тоноглогдсон танхим байсныг нотолж байгаа билээ. Эндээс олдсон уран зураг хийгээд товойлгон урласан ханын чимэглэл, суваргууд, том том шавар баримлуудаар чимэглэсэн лянхуа цэцгэн суудал тэргүүтэн нь зөвхөн Бүддийн шашны сүм дуган, хурлын танхимуудад л байдаг юм. XIII зууны үеийн Монголын хааны ордныг суварга, лянхуа цэцгийн суудал, эсвэл аварга том Бурхан Бүддагийн дүрс, бодисадва нарын баримлаар лав л чимэглэхгүй байсан гэж хэлж болох байх. Хархорум дахь “бурхан шүтээнийг тахиx ёслол”, (Бүддийн шашны) “бурхан шүтээний зургууд”-ыг сав л хийвэл муучлах гэдэг асан Рубрук ордны доторх Бүддийн шашны холбогдолтой баримлууд, бурхан шүтээний зүйлсийг тахиxтай холбоотой ханын зургуудыг үзээгүй юм уу, дурдалгүй өнгөрсөн гэх нь үнэн байдалд огт нийцэхгүй.

Рубрукийн тэмдэглэлд Хааны ордон нь тэг дөрвөлжин бус, харин уртаашаа сунасан тэгш өнцөгт хэлбэрийн барилгын тухай өгүүлсэн байдаг. Мөн Рашид ад-Диний дүрслэн бичсэнээр, уртаашаа сунасан тэгш өнцөгт танхим нь бүхэлдээ нэлээд цогцолбор маягийн байгууламж байжээ гэж үзэхээр байгаа бөгөөд тэр нь Хархорумын малтлагаар илэрсэн тэг дөрвөлжин хэлбэр

бүхий баганат танхимтай огт авцалдахгүй байна. Рашид ад-Дины тэмдэглэлд уг ордон нь “асар өндөр нэг барилга [...]” бүхий хэд хэдэн барилгагаас бүтсэн цогцолбор байгууламж бөгөөд төв хэсэгтээ “агуу их эзэгнэн захирагчийн өндөр зэрэг зиндаанд нийцсэн маш өндөр багануудтай, жигүүрийн барилгууд нь сум тусах дайны зайд байрласан” хэмээн тодорхойлжээ. Рубрукийнхээр бол Хааны ордон нь гурав юм уу, таван танхимтай, “яг л сүм шиг голдоо нэг том танхим, хоёр талдаа хоёр эгнээ багануудаар тусгаарлагдсан нэг нэг танхимтай” байсан.

Гэтэл бидний малтаж гаргаж ирсэн танхим нь тэг дөрвөлжин хэлбэртэй агаад нийт долоон өрөө буюу “йох”-той юм. “Юань гүрний эхэн үеийн асар”-ыг ч бас яг ийм долоон танхимтай, тэг дөрвөлжин байгууламж хэмээн тодорхойлсон байдаг:

“Хамгийн доод давхрын хувьд гэвэл [...] дөрвөн талдаа тасалгаатай, тасалгаа бүр нь долоон “йох” (өрөө)-той. Тэдгээрийг тойруулаад Бурхан Буддагийн янз бүрийн дүрс, баримлуудыг судар номд заасан ёсыг ягштал баримтлан байрлуулсан [...]”

Сүмийн асрын голд нэгэн суварга байх агаад энэхүү сүм нь нь Хааны ордны нэгэн адил “[...] үргэлжилсэн ханан хэрмээр хүрээлэгдсэн байна.” Сүмийг тодорхойлон бичсэн энэхүү тэмдэглэл бидний судалгааны дүнтэй тун ойролцоо байгаа нь илэрхий.

Аливаа үзэл баримтлалаас нэлээд хол ангид байдаг Хархорум судлалын нэг онцлог нь “Ордны талаарх судалгааны дүн”-г тайлбарлах, түүний “үнэн зөв”-ийг нотлоход практик ач холбогдол бүхий дорвилог хүчин зүйлс, тухайлбал Ордныг байгуулсан цаг хугацааны талаар өнөөг хүртэл ямар нэг маргаан өрнүүлж байгаагүй явдал мөн. Түүхийн сурвалж бичгүүдэд Ван-Ань ордныг 1235 оны хавар барьж эхэлсэн гэж гардаг ба энэ нь хэрвээ бид цаг агаарын хүндрэлтэй байдлыг харгалзан үзвэл сайндаа л 3-р сарын сүүлчээр гэсэн үг юм. Тэгээд ердөө дараа жилийнх нь хавар буюу 1236 оны 4-р сард ордныг барьж дуусгаад, нээлтийг баяр ёслолын байдалтай хийсэн байдаг. Гэтэл дүн өвлийн хахир хүйтэнд барилгын ажил нэг бол бүрмөсөн зогсдог, эсвэл

алдаг оног явдаг гэж үзвэл ордныг дээд тал нь найман сарын хугацаанд л барьжээ гэсэн үг юм. Хангамж үйлчилгээний хувьд нэлээд хүндрэлтэй байсан тухайн үеийн Хархорин хотод төр улсын чанартай ийм нүсэр том ордныг, 6.000 шоо метр эзэлхүүн бүхий суурийн хамт ийм богино хугацааны дотор амжин барьж дуусгасан гэж санаанд огтхон ч багтахгүй байна. Тэгвэл "Юань гүрний эхэн үеийн асар"-ыг барьж дуусгахад 5-20 жил зарцуулсан гэж байгаа. Сүмийг бүтээх барилгын ажил Төрэгэнэ хатан, Гүюг хааны үед үе үе тасалдсан буюу нэлээд хугацаагаар зогссон гэж үзсэн ч ерөнхийдөө хэд хэдэн жил үргэлжилсэн гэдгийг ямартай ч иш үндэс болгох ёстой юм. Барилгын суурь болон доод хэсгийг бүр өгэдэйг хаан ширээнд залж байхад барьсан хэмээн 1346 оны бичээст тэмдэглэсэн байдаг бол 1256 онд энэхүү барилгын дээд хэсгийг бүрэн барьж дууссан байна. Хожмоо 1342-1346 онуудад уг барилгыг өөрчилж, сэргээн засварлах ажилд л гэхэд дөрвөн жил шаардагдсан байна: "Дөрвөн жил өнгөрсөн хойно (энэхүү ажил) бүрэн өндөрлөв."

Киселевын ордон гээд байгаа нь бидний үзэж байгаагаар энэхүү бичээст гарч буй тэр сүм бололтой. Хархорумын Их танхим, "Юань гүрний эхэн үеийн асар" хоёр нь нэг барилга мөн эсэхийг эцэслэн дүгнэх боломж хараахан бүрдээгүй байна. Ямартай ч Монгол дахь Бүддийн шашны эрт үеийн (XVI зуунаас өмнөх) түүхийг цаашдаа Монголын түүх болон урлагийн түүхийн хавсарга мэтээр үзэн орхигдуулж болохгүй, ингэх ч ёсгүй гэдгийг Ордны малтлагын дүн харуулж буй юм.

Бидний бодлоор Өгэдэй хааны ордныг ямар ч байсан өөр газраас, магадгүй тэртээ 1892 онд Вильхелм Радловын үзэж байсанчилан Эрдэнэ зуу хийдийн талбайгаас л хайх хэрэгтэй болов уу. Ийм дүгнэлтэд хүргэх анхны нэлээд барьцтай үндэслэл бол 2005 оны 8-р сард хийдийн хойд талын хана хэрмийн хажууд байдаг нэгэн даланд бага зэргийн зүсэлт хийсэн явдал юм. Энэхүү малтлагаараа бид Эрдэнэ зуу хийдийг хүрээлсэн далангийн бүтэц, түүнийг барьж босгосон он цагийн талаар мэдээлэл олж авна хэмээн найдсан хэрэг. Тэгээд ч уг малтлагын үеэр тус хийдийн хэрэмний доор, цэвэр XIII-XIV зууны үеийн шавар вааран эдлэл бүхий шатсан давхаргын доороос маш эртний, лавтайяа Хархорумын үеийнх

Биймаар хана хэрэм нээн илрүүлсэн юм. Энэхүү хэрэм XIII зууны үеийн Хааны ордон байсан хотын гаднах хэрмийн хойд тал мөн эсэх нь 2006 оны зун хийх дараачийн малтлагуудаар тодорхой болох юм. Хана хэрмийг судалсан судалгааны дүн зүүн, баруун, үрд талын далангуудын хувьд ч мөн нотлогдвол бид ойрын үед Хааны ордон буюу Мөнхийн Амгалангийн ордны тууринд тулж орно хэмээн найдах үндэстэй болно.

Ерөнхийдөө Германы Судалгааны Нийгэмлэг (DFG)-ийн өгөөмөр тэтгэлэг, мөн Германы Эрдмийн Солилцооны Алба (DAAD)-ны дэмжлэгтэйгээр Германы Археологийн Хүрээлэнгийн хийж гүйцэтгэсэн Хархорумын Хааны ордны малтлагаар барилгын археологийн талаар санаанд оромгүй шинэ шинэ мэдээлэлтэй болсон төдийгүй, баганат танхимд хадгалагдан үлдсэн зүйлс болон шатаах зуухнуудаас олдсон олдворууд ихээхэн цогцолбор шинжтэй байсны ачаар дундад зууны үеийн Монголын түүхэнд холбогдох археологийн үндсэн материалуудыг олж авсан билээ. Нэн ялангуяа урлангуудаас олдсон арвин баялаг олдворууд нь Бүддийн шашны шавар урлалын болон ханын зургийн хэв маягийн үү шатлал, тэрчлэн Монголын уран барилга болон шаазан наарын урлагийг төрөл зүйлүүдээр нь ангилан тодорхойлоход маш даацтай суурь дэвсгэр болж өгнө. Хархорумд шинээр хийсэн малтлагууд Дундад зууны археологи болон Монголын урлагийн түүхэнд анх удаагаа түүх-археологийн талаасаа маш бат бэх суурь тавьж чадлаа.